



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/619

Булган сум

**Хөрсний шинжилгээ хийлгэхэд шаардагдах
хөрөнгийг гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа; нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Тариалангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын 3.3.4.13 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/23 дугаар Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөр батлах тухай” тогтоолын 2.4.3.1, 2.4.3.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IX/63 дугаар “Шинэ хөдөө сэргэлт хөтөлбөр батлах тухай” тогтоолын 4.4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд бэлчээрийн талбайгаас тариалангийн ангилалд шилжүүлэхээр санал ирүүлсэн Баян-Агт, Бугат, Могод, Орхон, Тэшиг сумдын нийт 2467.5 га талбайн хөрсний шинжилгээг Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй гэрээ байгуулж, гүйцэтгэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т үүрэг болгосугай.

2.Хөрсний шинжилгээ хийлгэхэд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний санхүүжилтээс зарцуулахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажлыг гэрээний дагуу чанартай хийлгэж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т, хөрсний шинжилгээний дүгнэлтийн дагуу газрын ангилалд шилжүүлэх тухай саналыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, ирүүлэхийг холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011004

Сүхбаатар аймгийн Засаг дарга 2025 өдөр бү...

Аймгийн Засаг даргын 2025 оны
10 дугаар сарын 15-ны ний өдрийн
А/ОНЗ дугаар захирамжийн хавсралт



**БЭЛЧЭЭРИЙН ТАЛБАЙГААС ТАРИАЛАНГИЙН
АНГИЛАЛД ШИЛЖҮҮЛЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ**

| д/д | Сумын нэр | Байршлын тоо | Талбайн хэмжээ |
|-----|-------------|--------------|------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Баян-Агт | 3 | 333 га |
| 2 | Бугат | 7 | 325.5 га |
| 3 | Могод | 3 | 1495 га |
| 4 | Орхон | 3 | 300 га |
| 5 | Тэшиг | 1 | 14 га |
| | Бүгд | 17 | 2467.5 га |